

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
САЙДЫН ТУШААЛ

2023 оны ... дугаар  
сарын . . .-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэг, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хадгалах, ашиглах, мэдээлэлд хяналт тавих, нууцлал, аюулгүй байдлыг хангах журмыг нэгдүгээр, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний мэдээллийн санг бүрдүүлэх, боловсруулах, түгээх, ашиглах, хянах, хадгалах, хамгаалах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Б.Батжаргал)-т, хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Л.Мөнхзул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

САЙД

Х.БУЛГАНТУЯА

Төсөл  
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын  
2023 оны ... дугаар сарын ...-ны өдрийн  
.../... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

НИЙГМИЙН ДААТГАЛЫН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГ БҮРДҮҮЛЭХ,  
ХАДГАЛАХ, АШИГЛАХ, МЭДЭЭЛЭЛД ХЯНАЛТ ТАВИХ, НУУЦЛАЛ,  
АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сан (цаашид “мэдээллийн нэгдсэн сан” гэх)-г бүрдүүлэх, хадгалах, ашиглах, мэдээлэлд хяналт тавих, нууцлал, аюулгүй байдлыг хангах, мэдээллийн нэгдсэн сангаас даатгуулагч, иргэн, ажил олгогч, төрийн болон бусад байгууллагад нийгмийн даатгалын үйлчилгээг үзүүлэхтэй холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хадгалах, ашиглах, мэдээлэлд хяналт тавих, нууцлал, аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагааг хангах, мэдээллийг тухай бүр шинэчлэх чиглэлээр нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (цаашид “Нийгмийн даатгалын ерөнхий газар” гэх) мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.

Хоёр. Мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, боловсруулах

2.1.Мэдээллийн нэгдсэн сан нь Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 17 дугаар зүйлийн 17.1, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 16 дугаар зүйлийн 16.3.1-д дэх хэсэгт заасан мэдээлэл болон нийгмийн даатгалын бусад хууль тогтоомжтой нийцүүлэн гарсан дүрэм, журмын дагуу бүрдүүлсэн цахим мэдээллээс бүрдэнэ.

2.2.Мэдээллийн нэгдсэн санг үнэн зөв бүрдүүлэх үүргийг Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын газар, сум, дүүргийн тасаг, байцаагч, ажилтан (цаашид “нийгмийн даатгалын байгууллага” гэх) хариуцна.

2.3.Нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах бусад мэдээллийг холбогдох төрийн болон бусад байгууллагатай харилцан солилцох зарчмыг баримтална.

2.4.Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 17 дугаар зүйлийн 17.3-т заасан зорилгоор төрийн бусад байгууллагын суурь болон төрөлжсөн мэдээллийн санд бүртгэгдсэн мэдээллийг ашиглахдаа Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 18 дугаар зүйлийн 18.3-т заасан үндсэн систем /цаашид “үндсэн систем” гэх/-ээр дамжуулна.

2.5.Нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээллийн технологийн үйл ажиллагаа хариуцсан нэгж харьяа нэгж нь мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу бүрдүүлэх, ашиглах, боловсруулах үйл ажиллагааг мэдээллийн технологиор дэмжиж ажиллана.

Гурав. Мэдээллийн нэгдсэн санг хадгалах, ашиглах,  
мэдээллийн сангийн аюулгүй байдал

3.1.Мэдээллийн нэгдсэн санг хадгалах, хамгаалах, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг Нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээллийн технологийн үйл ажиллагаа хариуцсан нэгж нэгж хариуцна.

3.2 Нийгмийн даатгалын ерөнхий газар нь мэдээллийн нэгдсэн санг байршуулах, хадгалах, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаатай холбоотой зориулалтын серверийн өрөөтэй байна.

3.3.Мэдээллийн аюулгүй, найдвартай байдлыг хангах, гуравдагч этгээдэд ашиглуулах үүднээс даатгуулагч, ажил олгогчтой холбоотой мэдээллийн санг Үндэсний дата төв УТҮГ-т давхар байршуулна.

3.4. Нийгмийн даатгалын ерөнхий газар нь байгалийн гамшиг, гал усны болон гэнэтийн бусад аюул, халдлага, устаж үрэгдэж болзошгүй бусад нөлөөллөөс хамгаалах зорилгоор мэдээллийн санд байгаа өгөгдөл, мэдээллийг жил бүр нөөцөлж, аюулгүй байдлын болон техникийн шаардлага хангасан газарт хадгална.

3.5.Мэдээллийн нэгдсэн сангаас даатгуулагч, ажил олгогчдод үйлчилгээ үзүүлэх, мэдээллийн нэгдсэн санг ашиглахад Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай, Байгууллагын нууцын тухай болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг баримтална.

3.6.Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүднээс мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, ашиглаж буй хэрэглэгч нь нэвтрэх эрхтэй байна.

3.7. Мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийн үнэн зөв байдал, ашиглалтад Нийгмийн даатгалын ерөнхий газрын дотоод аудит хариуцсан зохион байгуулалтын нэгж хяналт тавьж ажиллана.

3.8.Мэдээллийн технологийн үйл ажиллагаа хариуцсан нэгж нэгж нь онцгой нөхцөл үүссэн үед мэдээллийн нэгдсэн сан, мэдээллийн системээ нөхөн сэргээх төлөвлөгөөтэй байна.

3.9.Мэдээллийн технологийн үйл ажиллагаа хариуцсан нэгж нэгж нь мэдээллийн нэгдсэн сангийн хадгалалт, нөөцлөлт, аюулгүй байдлыг хангах чиглэлээр дотооддоо журмыг баталж мөрдөнө.

3.10.Мэдээллийн нэгдсэн санг ашиглах явцад мэдээлэл алдагдах, устах зэрэг аюултай нөхцөл байдал үүссэн тохиолдолд гэм буруутай этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

#### Дөрөв.Мэдээллийн нэгдсэн сангаас нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлэх

4.1.Нийгмийн даатгалын ерөнхий газар нь мэдээллийн сангийн мэдээлэлд үндэслэн Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд заасан үйлчилгээг үзүүлнэ.

4.2. Нийгмийн даатгалын үйлчилгээг үзүүлэхэд мэдээллийн нэгдсэн санд байхгүй шаардлагатай баримт, бичгийг ажил олгогч, даатгуулагчаас цаасан болон цахим хэлбэрээр авч болно.

4.3.Нийгмийн даатгалын ерөнхий газар нь мэдээллийн нэгдсэн сангаас ажил олгогч, даатгуулагч, тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр авагчдийн талаарх лавлагаа, тодорхойлолтыг цахимаар эсхүл цаасан хэлбэрээр авах боломжийг бүрдүүлнэ.

4.4.Нийгмийн даатгалын ерөнхий газар нь энэ журмын 4.3-д заасан үйлчилгээг төрийн болон бусад байгууллагад үндсэн системээр дамжуулан үзүүлнэ.

4.5.Нийгмийн даатгалын ерөнхий газар нь төрийн болон бусад байгууллага, хувь хүн болон нийгмийн судалгааны байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэж Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасан нээлттэй өгөгдлийг цахимаар болон цаасан хэлбэрээр ашиглах боломжийг бүрдүүлнэ.

#### Тав. Бусад зүйл

5.1.Нийгмийн даатгалын ерөнхий газар нь мэдээллийн нэгдсэн сангийн аюулгүй байдал, хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг хангах, програм болон техник хангамжийг шинэчлэх, нэгдсэн сүлжээг өргөжүүлэх, засвар, үйлчилгээ хийх зэрэг үйл ажиллагаанд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусган батлуулна.

5.2.Мэдээллийн нэгдсэн сангийн үнэн зөв байдал, аюулгүй ажиллагаа, ажил олгогч, даатгуулагч, тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр авагчид олгох мэдээлэл, лавлагаа, тодорхойлолтод Нийгмийн даатгалын ерөнхий газар хяналт тавьж ажиллана.

5.3.Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хуулийн тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

Төсөл  
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын  
2023 оны ... дугаар сарын ...-ны өдрийн  
.../... дугаар тушаалын хоёрдугаар  
хавсралт

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ  
ДААТГАЛЫН МЭДЭЭЛЛИЙН САНГ БҮРДҮҮЛЭХ, БОЛОВСРУУЛАХ,  
ТҮГЭЭХ, АШИГЛАХ, ХЯНАХ, ХАДГАЛАХ, ХАМГААЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын мэдээллийн сан /цаашид “мэдээллийн сан” гэх/-г бүрдүүлэх, боловсруулах, түгээх, ашиглах, хянах, хадгалах, хамгаалах үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2.Мэдээллийн сан нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн үйл ажиллагаанд хяналт, судалгаа шинжилгээ, үнэлгээ, тооцоолол хийх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

1.3.Мэдээллийн сан нь нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сангийн хэсэг байна.

Хоёр.Мэдээллийн санг бүрдүүлэх, боловсруулах, түгээх

2.1.Мэдээллийн сан нь Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 16.1-д заасан мэдээлэл, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.6<sup>1</sup>-д заасан мэдээллийн сангийн мэдээлэл болон эдгээр хууль, тогтоомжтой нийцүүлэн гарсан дүрэм, журмын дагуу бүрдүүлсэн мэдээллээс бүрдэнэ.

2.2.Мэдээллийн санг бүрдүүлэх үүргийг Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 16 дугаар зүйлийн 16.3-т заасны дагуу холбогдох байгууллагууд хариуцна.

2.3.Энэ журмын 2.2-т заасан үүрэг бүхий байгууллага нь мэдээллийн сангийн үнэн зөв байдлыг хариуцаж, мэдээллийг тогтмол шинэчилж байна.

2.4.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 16 дугаар зүйлийн 16.3.2, 16.3.3-д заасан байгууллага нь нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад холбогдох мэдээллийг цахимаар авах боломжийг бүрдүүлж өгч, хамтран ажиллана.

## Гурав.Мэдээлэл ашиглах, хянах

3.1.Энэ журмын 2.2-т заасан байгууллагууд нь цахим хэлбэрээр мэдээлэл солилцохдоо Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 18 дугаар зүйлийн 18.3-т заасан үндсэн системийг ашиглана.

3.2.Мэдээллийн санг даатгуулагчид тэтгэвэр, тэтгэмж тогтоох, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн төлбөр зардал олгох болон мэдээллийн боловсруулалтад ашиглана.

3.3. Мэдээллийн сангийн ашиглалтад энэ журмын 2.2-т заасан үүрэг бүхий байгууллага нь өөрсдийн чиг үүргийн дагуу хяналт тавьж ажиллана.

## Дөрөв.Мэдээллийн санг хадгалах, хамгаалах

4.1. Энэ журмын 2.2-т заасан үүрэг бүхий байгууллага нь өөрсдийн чиг үүргийн дагуу мэдээллийг хадгалах, хамгаалах, нөөцлөх ажлыг хариуцна.

4.2.Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүднээс мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, ашиглаж буй хэрэглэгч нь нэвтрэх эрхтэй байна.

4.3.Төрийн болон бусад байгууллагын ажилтан энэ журамд заасан цахим мэдээллийг албаны бус зориулалтаар ашиглах, хуулбарлах, бусдад дамжуулах, задруулахыг хориглоно.

4.4.Мэдээллийн санг ашиглах явцад мэдээлэл алдагдах, устах зэрэг аюултай нөхцөл байдал үүссэн тохиолдолд гэм буруутай этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

## Тав. Бусад зүйл

5.1.Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---

<sup>1</sup> 22.1.6.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын талаарх тайланг гаргах, хөдөлмөрийн хортой, аюултай нөхцөл бүхий ажлын байрны мэдээллийн сан бүрдүүлэх, холбогдох газар, олон нийтэд мэдээлэх;